

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГТААР

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жигдээ

№ 82 (2385)

1974 оны 11 дүгээр сарын 4

ДАВАА

Хэсгийн тэргүүний ахлагч

Жаргалантын САА-н төвийн тасгийн ногооны 6 дугаар бригадын хэсгийн ахлагч Н.Цогцолмаа 1973 оноос эхлэн МХЗЭ-ийн илгээлтээр ХАА-н үйлдвэрлэлд гарч ажиллагчдыг хариуцан авч хэсэг зохион байгуулан ажиллаж байна. Н.Цогцолмаагийн хариуцсан хэсэг 1974 оны ургац хураалтаар сонгиноо хураах төлөвлөгөөгөө 120,9—130 хувиар биелүүлсэний дотор ногоочин-Цэрэннадмид, Баасанжав нар төлөвлөгөөгөө 8—14,8 хувиар давуулав.

Тус хэсгийн хамт олон одоо социалист хөдөлмөрийн төлөө бригадын үүрэг аваад ажиллаж байна.

Ш.ЯДАМСҮРАН

БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧДИЙН ЧУХАЛ ЗОРИЛТ

Манай аймгийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт 600 илүү багш, хүмүүжүүлэгчид ажиллаж байгаагийн 98,5 хувь нь сурган хүмүүжүүлэх дээд, дунд боловсролтой хүмүүс юм.

МАХН-ын Төв Хорооноос хүүхдийн хүмүүжил, ардын боловсролын ажлын талаар удаа дараалан гаргасан тогтоолыг хэрэгжүүлэн V таван жилийн төлөвлөгөөнд ардын боловсролын байгууллагын талаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх их ажилд багш нарын хуримтлуулсан туршлагыг нэгтгэн дүгнэж цаашдын зорилтыг улам тодруулах зорилгоор 1975 онд болох улсын багш нарын зөвлөлтөөн ойтсоор байна. Багш нарын III их хурлаас хойших хугацаанд 8—12 насны бүх хүүхдийг нийтээр нь бага сургуулиар хамран сургаж улмаар бүрэн бус дунд боловсролтой болгох зорилт амжилттай шийдвэрлэгдэж байна.

Аймгийн хэмжээгээр 1973—1974 оны хичээлийн жилд 92,2 хувийн сурлагын амжилт үзүүлсний дотор 29,8 хувийг онцсаны ба сайн сурлагатан эзэлж Бүрэн сумын дунд сургуулийн багш Цэрэнбух, Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн багш Бямбаа, төвийн 10 жилийн дунд сургуулийн багш Батнасан нарын 106 багш даасан ангиа, Мөнгөнморьт сумын дунд сургуулийн багш Нордажав, Засмар сумын дунд сургуулийн багш Цэрэнноров, Баяндэлгэр сумын дунд сургуулийн багш Цэрэнханд нарын 95 багш заадаг хичээлээ 100 хувь, Батсүмбэр сумын дунд сургуулийн бага ангийн багш Лхамцэрэн 1972 онд хүлээн авсан 1 дүгээр ангиа амжилттай төгсгөн нэг ч сурагчдыг улируулалгүйгээр, 61 хувийн онцсайн ба сайны эзлэх хувийн жинтэйгээр 3 дугаар ангийг төгсгөж сайхан амжилт гаргалаа.

Одоо аймгийн хэмжээгээр 13—49 насны бүх хүний 81,2 хувь нь анхан шатны ба түүнээс дээш боловсролтой болж, аймгийн АДХ-ын 8 дахь удаагийн IV чуулганаас дэвшүүлсэн зорилт амжилттай биелэгдэж байна. Улсын багш нарын зөвлөлтөөн, МПБ-ын 50 жилийн ойг угтаж Баяндэлгэр сумын дунд сургууль ЗСБНХОУ-ын Курган мужийн багш нарын мэргэжил дээшлүүлэх институттэй харилцаа тогтоон ажиллаж сургалтын ажлыг шинжлэх ухааны үндэстэй удирддаг аргыг, Москва хотын 706 дугаар сургуулийн тэргүүний багш нарын хичээлийн үр дүнг дээшлүүлж анги улируулахгүй сургадаг туршлагыг нэвтрүүлэн ажиллаж зохих амжилтанд хүрч байна.

Гэвч тус аймагт сургууль завсардах, пионер сурагчдын хүмүүжил доголдож зөрчил гаргах, анги улирдаг явдал байсаар байгаад сургууль, багш, ардын боловсролын ажилтан бүр зохих дүгнэлт хийвэл зохино.

Багш хүмүүжүүлэгчид, сурган хүмүүжүүлэх ажлынхаа үр нөлөөг сайжруулж, сургалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшил, социалист бүтээн байгуулалтын өнөөгийн шаардлагатай нягт холбоход онцлон анхаарах хэрэгтэй. Юуны өмнө сурагчдад гүнзгий мэдлэг, чадвар одгон хичээлийн хүмүүжүүлэх нөлөө, сургалтын үр дүнг дээшлүүлж, хүүхдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлэн сурагчдын дунд зохиох хүмүүжлийн ажлыг чанаржуулахад сургууль, эцэг эх, албан үйлдвэрийн газрын хамтын ажиллагааг сайжруулж хөдөлмөрдлийн дунд зохиох сурган хүмүүжүүлэх суртал нэвтрүүлгийн ажлыг хүчтэй болговол зохино. Сургуулийн насны бүх хүүхдийг нийтээр нь бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлэн сурагчдыг завсардуулалгүй, улируулалгүйгээр сургах нь сургууль багш нарын эрхэм үүрэг мөн. Иймийн тулд багш бүхэн ээлжит хичээл бүрт сайн бэлтгэх, сурагчдын биеэ даасан идэвхтэй үйл ажиллагааг хөгжүүлэх, хичээл бүрийн сэдвийн заах аргыг шинэчлэн боловсруулах, өөрийн орны болон ЗХУ, ах дүү социалист орны сурган хүмүүжүүлэх ухааны ололт туршлагаас ямагт суралцах, улс төрийн боловсрол, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж улсын багш нарын зөвлөлтөөнийг ажлын амжилтаар угтах явдал нийт багш хүмүүжүүлэгчдийн чухал зорилт мөн.

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНЫ АЙЛЧЛАЛД

АЖИЛ НЬ АХИЦТАЙ

Баянзүрх сумын Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Нэгдлийн зөвлөл, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхт ойг угтаж сумын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтуудыг хугацаанаас нь өмнө жигд биелүүлэхийн тулд намын үзэл суртал, зохион байгуулалтын ажлын далайц, арга барилыг улам сайжруулж социалист уралдааныг ерүүлэн ажиллаж байна.

Үүний үрээр бүх төрлийн ноос бэлтгэлийн төлөвлөгөөг 102—115, бараа, ном борлуулалтыг 100—112, хөлдүү түүхий эд, ангийн үсний II төрлийн зүйлийн төлөвлөгөөг жилээр, холбооны салбар, кино, эмийн сан, цэцэрлэгийн орлогын төлөвлөгөө 100—185 хувиар биелэгдэж системийн байгууллагуудын уралдаанд хагас жилээр 2,3 дугаар байр эзэлжээ.

Хашаа барих, худаг

гаргах, байгалийн хадлан авах төлөвлөгөө 100—100,4 хувиар биелсэний гадна энэ оны төл бэйжилт 107,6 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мал дээрээ 5000 толгой мал нэмж боломжийн төлөвлөгөөг биелүүлэх боллоо олжээ.

Энэ жил Баянзүрх сумын ажил өөдрөг сайн байгаагийн нэг жишээ нь тус сум өнгөрсөн онд аймагтаа ажлаараа 21 дүгээр байранд орж байсан бол энэ оны 3 дугаар улирлын ажлаар 6 дугаар байранд нэгдлүүдийн дотороос 3 дугаар байранд оржээ. Тус сумын намын хорооны нарийн бичгийн дарга Чимэд ярихдаа:

—Төлөвлөгөөт ажлын явцад 7 хоног бүр судалгаа дүгнэлт хийж социалист уралдааныг эрчимжүүлсэн нь амжилтын үндэс болов.

Хүмүүсийн гүйцэтгэх үүргийг нарийн хугацаатай тодорхой зааж, хяналт шалгалтыг байнга

үр дүнтэй явуулан ажлыг нь дүгнэн түүнийг нийтийн өмнө таниулж дахин үүрэг амлалт авахуулах ажил зохиов.

Бригад суурийг мал аж ахуйн хэсгийн зохион байгуулалтанд оруулж хүмүүсийн үзэл санаа, ажил хөдөлмөрийн нэгдлийг хангаж бие биэндээ тавих хяналт шаардлага, ажил хариуцах хариуцлагыг дээшлүүлсэн юм.

Удирдах хариуцлагатнуудыг суурь, хэсгүүдээр явуулж хөдөлмөрдлийн санал хүсэлтийг авч ажилдсан зэрэг нь ажлыг ахиулахад ач холбогдолтой боллоо гэв. Ийнхүү ажлынхаа амжилтанд урамшсан Баянзүрх сумын хамт олон энэ оны төлөвлөгөөт зорилтоо хугацаанаас нь өмнө нэр төрдөөр нь биелүүлж Л.И. Брежнев тэргүүтэй Зөвлөлт Холбоот Улсын нам, засгийн төлөөлөгчид манай оронд хүрэлцэн ирэх түүхт үйл явдлыг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах эрмэлзлэл төгс ажиллаж байна.

Л.СОДНОМДАРЖАА

АЙМГИЙН НАМЫН ХОРООНД

Саяхан аймгийн Намын хорооны товчоо «Хэвлэл, радиогийн шүүмжлэлийн мөрөөр зохино байгаа ажлын тухай» Лүн сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Гончигийн илтгэлийг хэлэлцэж тогтоол гаргав. Уг тогтоолд:

Лүн сумын намын байгууллага хэвлэл, радиогийн шүүмжлэлийн мөрөөр зохиох ажлын тухай намын үүрийн товчооны хурлаар хэлэлцэж, шүүмжлэлийн мөрөөр ажиллах группийг байгуулан илэрсэн дутагдлыг богино хугацаанд засах, хэвлэл нийтлэгдсэн дохио санамж болон сумынхаа амжилттай шууд холбогдолтой шүүмжлэлийн талаар зохих эздэд нь шаардах хуудас, албан даалгавар бичих, уул сонинг гардуулах, хамт олны хурлаар хэлэлцэн авах арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг дүгнэж, радиогийн газруудад хариу мэдэгдэх зэрэг ажил зохиож байна.

Гэвч төв, орон нутгийн хэвлэл радиогийн шүүмжлэлийн мөрөөр зохиох ажлыг сумын намын байгууллагаас хангалтгүй

удирдаж зарим талаар ёс төдий хандаж, дутагдлыг эрс шийдвэртэй засч хариуг өгөхгүй дарж өнгөрүүлж явдал арилаагүй байна.

Тус суманд төв, орон нутгийн хэвлэлийг хөдөлмөрдөөр өргөн захиалуулах ажил хангалтгүй явагдаж иржээ. Сумын зарим хариуцлагатны дотор зөв шуудага шүүмжлэлийг элдвээр тайлбарлах, дутагдлаа «мөөрөх буюу эсвэл арга хэмжээ авсан гэж худал мэдээлэх зэргээр шүүмжлэлтэй зөв зохистой харьцаж чадахгүй байгаа дутагдал гарч байсныг тэмдэглэж тогтоохдоо:

—Намын үзэл суртлын ажлын хурц зэвсэг хэвлэл, радиогийн зохион байгууллага, хүмүүжүүлэгч рөлийг дээшлүүлэхийн тулд хэвлэл-радиогийн шүүмжлэлийн мөрөөр зохих ажлыг хүчтэй болгон тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх, дохио, шүүмжлэл өгөгдсөн дутагдлыг шуурхай засч байхыг нам, төр, олон нийт, аж ахуй, соёлын нийт байгууллагын чухал үүрэг болгожээ.

—Хэвлэл, радиогийн шүүмжлэл, дохио бүрийг нам, олон нийтийн байгууллага хөдөлмөрийн хамт олноор хэлэлцүүлэн дутагдлыг засах тодорхой арга хэмжээ авч, зохиосон ажил ба үр дүнг холбогдох хэвлэл, радиогийн газарт тухай бүрт нь мэдэгдэж байх.

—Хэвлэл, радиогийн шүүмжлэлийн мөрөөр эрхэн ажиллаж байгааг харьяа байгууллагууд дээр тогтмол шалгаж тэдгээр байгууллагын удирдах ажилтны илтгэл сонсоглыг авч хэлэлцэж байх.

—Хэвлэл, радиогоор нам, улс, олон нийтийн байгууллага, аж ахуй, соёлын газар бүрт тус газрын нэр заасан буюу нэр заагаагүй боловч холбогдох шүүмжлэлийн мөрөөр авсан арга хэмжээ, ажил нэвтрүүлсэн тэргүүн туршлагыг «Манай хамт олон хэвлэлийн хуудсанд» гэсэн дэвтэрт бүртгэж, хагас бүтэн жилийнхээ ажлын тайланд заавал дүгнэж оруулж байх.

—Хэвлэлийн зарчимч

(Төгсгөл нь II нүүрт)

АЙМГИЙН НАМЫН ХОРООНД

Тогсгол. (Түрүүч нь
I цүүрт)

шүүмжлэлийг хэрэгжүүлэх ажлын явцад намын хяналтыг нэвтрүүлж нийт боловсон хүчнийг хэвлэлийн шүүмжлэлд соргог гавшгай ажил хэрэгчээр зөв, шуларга хандаг болгон хүмүүжүүлэх.

—Айл өрхийг радиожуулах ажлыг цаашид эрчимжүүлэх, төв, орон нутгийн хэвлэлийг хөдөлмөрчдийн сайн дурын үндсэн дээр өргөн захиалуулж түүнийг хугацаанд нь хүргэж ашиглалтыг сайжруулах тодорхой ажлыг зохиохыг намын хороо, үүрүүдэд даалгажээ.

—Шинэ санаачлага тэргүүн туршлагын үр дүн ач холбогдлыг тэргүүний хүмүүсийн ажлын арга барил, ухамсар, зан суртахууны чанар, байгууллага, хамт олны үйл ажиллагаатай нягт холбоон нийтэлж байх.

—Шүүмжлэлийн материал нь сайтар шалгагдсан үнэн зөв бөгөөд ажлын аливаа дутагдлын уг

шалтгааныг илрүүлэн түүнийг засч сайжруулах арга замыг зааж чадсан байх.

—Ажлын доголдол, дагдал хүнд суртлын элдэв илрэл, хуучин нийгмийн зан суртахууны үлдэгдлийг илчлэн шүүмжлэх явдлыг хүчтэй болгох.

—Хэвлэлд шүүмжлэгдсэн шүүмжлэлийг 10 хоногийн дотор холбогдох байгууллага, эзэд нь албан ёсоор мэдэгдэж уул шүүмжлэлийн мөрөөр шалгах ажилд сонинны зөвлөлийн гишүүд, сурвалжлагч, илэвхтнийг өргөн оролцуулж хамтын үзэл, гийн аргыг өргөн хэрэглэж байхыг «Анхдугаар таван жил» сонинны харилцаагатай эрхлэгч Д. Товууд үүрэг болгожээ.

Нийт сумдад хэвлэл, шуудан хүргэх ажлыг сайжруулан, хэвлэлийн захиалагчдад хүргэсэн байдлыг бүртгэх журналыг энэ онд багтаан хэвлүүлэхийг аймгийн Харилцаа холбоо (н. Неролхоо)-д даалгажээ.

ТАЙЛАН СОНГУУЛИЙН ХУРАЛД САЙН БЭЛТГЭЭ

МҮЭ-ийн Төв Зөвлөл, Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагын тайлан сонгуулийн хурлыг 1974 оны 11 дүгээр сарын 1-нээс 30-ны дотор багтаан, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тун хагласны 50 жилийн ой угтаж 1974 оны төлөвлөгөөт зорилтыг жигд биелүүлэх уриан дор зохион явуулахаар шийдвэрлэж тогтоол гаргав.

Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллага бүхэн дотоод зохион бай

гуулалт, аж ахуй, улс төр, хүмүүжлийн ажлаа улам сайжруулах үндсэн дээр тайлан сонгуулийн хурлын бэлтгэлийг эрчимтэй хангах нь одоогийн ээлжит зорилт мөн.

Энэ жилийн тайлан сонгуулийн хурлын онцлог нь үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллага, илэвхтэн бүр МҮЭ-ийн Төв Зөвлөлийн IV бүгд, аймгийн үйлдвэрчний эвлэлийн XVII бага хурлын шийдвэрийг биел

(Тогсгол нь IV цүүрт)

Монгол—Зөвлөлтийн найрамдлын сард

МАРТАГДАШГҮЙ ЕСӨН ӨДӨР

Жирийн тракторч би үзэсгэлэнт Фрунз хотод болсон Зөвлөлт—Монголын залуучуудын V их нааламд оролцсондоо хязгааргүй их баяр хөөр бял хуулан, их наалмын есөн өдрийн бүхий л үйл ажиллагаа мартагдашгүй дурдатгал болон сэтгэлд хоногшижээ.

Их наалмын өдрүүд Зөвлөлт—Монголын залуучууд бидний дунд ойр дотно танилцаж, бие биенээ ойлгох, ажил төрийн туршлага судлах, авъяас чадварын охь дээжийг харилцан суралцах нэг ёсны их сургууль болсон билээ.

Их наалмын арга хэмжээ хүний сэтгэл хөдөлгөөн онцгой сонин үйл явдал дүүрэн байлаа.

Түүний нэг нь найрамдал клубын нээлт байв.

Энд манай хоёр орны залуучууд их наалмын хүндэт төлөөлөгч, ЗХУ-ын баатар, нисэх хүчний маршал А.В. Судец, ЗХУ-ын баатар, домогт нисгэгч М. П. Чечнева, «Мон

гол ард» танкийн бригадын командлагч байсан ЗХУ-ын хошой баатар, армийн генерал И. И. Гусакковский, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, хоньчин Бат-очир нарын ахмадын сургаалыг сонсч, харилцан туршлагаа солилцож, хөгжөөнт үдэшлэгт оролцож, уран сайхны тоглолтыг сэтгэл дүүрэн үзэж байсан.

Их наалмын өдрүүдэд морин спортын наалдыг үзэж, хурдан хяргатгачдын тэмцээнийг сонирхож, Киргизийн үйлдвэр, хөдөө аж ахуйтай танилцаж, Зөвлөлтийн баатарлаг ард түмний хичнээн их хөдөлмөрч ажилсагийг мэдэрсч авсан билээ.

ХАА-н машины үйлдвэрээр ороход бидний өвс хадлангаа авахад хэрэглэж байгаа хадуур, хамаан боогчийг үйлдвэрлэж байсан нь тун сонин санагдаж, өндөр бүтээлт энэ машин механизмыг манай улсын хэрэгцээнд зориулан үйлдвэрлэж байгаа ажилчдад манай төлөө

лөгчид баяр хүргэсэн.

Их наалмын үеэр Ленинградын окутан, Украинны тарначин, Узбекикийн хөвөнч, Буриадны хоньчин, Таджикийн бүжигч, Казаккийн оёдолчин гээд олон ястан үндэстний охид, хөвгүүдтэй танилцаж анд найз боллоо.

Ийнхүү их наалам нь манай хоёр орны залуу үеийнхний найрамдал нөхөрлөлийг улам зузаатгаж өгсөн билээ.

Би нутагтаа ирээд их наалмын сонин, Зөвлөлт-Киргизийн хөгжилтөөс нөхөдөө ярьж өгч залуучуудтай уулзалт хийж зочломтгой тэндэхийн ард түмний амжилт ололтыг сурталчилж байна.

Наадад өндөр итгэл найдвар хүлээлгэж нарлаг Киргизийн их нааламд зочноор оролцуулсан МХЗЭ-ийнхээ хайр шагналын хариуд эрхэлсэн ажил хөдөлмөр дээрээ өндөр амжилт гаргаа илэрхийлэе.

Их наалмын төлөөлөгч Баяндогтын САА-н трактор-комбайнч, ХЗЭ-ийн ахууш Д. ДАМДИНГОМБО

НОМЫН ЕРТӨНЦӨД

ЗХУ-ын 200 гаруй хэвлэлийн газар жилд дундаар 8500 гаруй нэр төрлийн номыг 370 сая гаруй хувиар хэвлэдэг ба 86 мянган хүн ажилладаг 14,5 мянган дэлгүүр, 35 мянган мухлагаар дамжин ном борлогдоно.

ЗХУ-ын томоохон 100 гаруй номын сан дэлхийн 122 орны 5000 номын сан, байгууллагатай ном солилцож бийдэг аж.

Бүх холбоотын «Международная книга» гэдэг

нэгдэл Зөвлөлтийн ном зохиолыг хилийн чанадад түгээх ажлыг эрхлэдэг байна.

Ном худалдаалах энэ томоохон нэгдэл дэлхийн 110 орны номын худалдааны 100 гаруй байгууллагатай байнгын холбоотой ажилладаг юм.

Зөвлөлт засгийн жилүүдэд 2,4 сая гаруй нэр төрлийн ном товхимол 38 миллиард хувиар хэвлэгдэн гарчээ.



500—3000
литрээр

Борнуурын сангийн аж ахуйн саальчин М. Жавзмаа, Ч. Үзмээ нар 1974 онд тус бүр 25250 литр сүү саах төлөвлөгөөгөө 10 дугаар сарын 12-ны байдлаар 500—3000 гаруй литр сүүгээр давуулан биелүүлж, социалист уралдаанд хошуучилж явна.

БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОИД

БНМАУ-ЫН СТАТИСТИКИЙН АЛБА

БНМАУ-ын статистикийн байгууллага 1924 онд үүсч байгуулагдсан бөгөөд өөрийнхөө түүхэн 50 жилийн хугацаанд улс орны эдийн засгийн үндсийг бэхжүүлэх, улс ардын аж ахуйн бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харьцааг тогтоон хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж зохион байгуулалт гаргалын хувьд улам бүр боловсронгуй болж үйл ажиллагааны хүрээ нь өргөжин бэхжсээр ирэв.

1925—1940 онд тус улсын статистикийн алба нь нам, засгаас авч явуулсан ардчилсан арга хэмжээг биелүүлэн феодад ангийн эдийн засгийн эрх хэмжээг хязгаарлан ардын хувьсгалыг батжуулан социалист үндсийг бий болгоход голажаа чиглүүлж байв.

Ардын хувьсгалын ардчилсан шатны зорилтыг

биелүүлэхэд Монголын Статистикийн алба дараалсан тодорхой ажил зохиож тус орны хөдөлмөрчин олон түмний бүртгэл тооцонд сурган хүмүүжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Тус оронд социалист арга хэмжээ тууштай авагдан арга зүй хөгжиж эхлэхийн хамт статистикийн албаны гүйцэтгэх хүрээ өргөжин, төлөвлөлийн шинжлэх ухааны үндсийг сайжруулах, гүйцэтгэлийг хянах тодорхой үүргүүдтэй болж ирсэн юм. ХАА-д социалист систем алж үйлдвэрлэлийн хэрэгсэл бүх ард түмний өмч болон улс ардын аж ахуйд социалист харилцаа бүрэн ялсан нь улс орон нутгийн эдийн засгийн амьдралд бүртгэлээр шууд хяналт тавьж нэгдсэн төлөвлөгөөгөөр удирдан чиглүүлэх материал

лаг үндсийг бүрэлдүүлжээ.

1960 оноос манай бүртгэл статистикийн албаны хөгжлийн шинэ үе шат эхэлсэн нь статистикийн албаны түүхэнд онцгой үе шат болсон юм.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 4 дүгээр сарын зарлигаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэд улсын тоо бүртгэлийн төв газрыг байгуулж, аймаг, хотод шууд харьяа товчоол, сумдад тоо бүртгэлийн ажил хариуцсан орлогч дарга нарыг бий болгов.

Ингэж төв орон нутагт биеэ даасан аппаратууд байгуулагдсанаар улс ардын аж ахуйн бүх салбарын улсын тайлан мэдээг төвлөрүүлсэн нь улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт ажлын биелэлийг тогтмол хянахад ач

холбогдолтой болж шуурхай мэдээллийг нэгтгэн боловсруулах, улс ардын аж ахуйн материалын баланс зохиох, хүн амын өрхийн төсвийн түүвэр судалгаа, хүн амын ердийн хөдөлгөөн, хэтийн төлөвийн тооцоо, үйлдвэр аж ахуйн газруудын тайлан балансын нэгтгэлийн, эдийн засгийн үүргийн ашгийн тооцоо, худалдааны ашиг зах зээлийн тооцоо, эдийн засгийн статистикийн бусад судалгааны ажил, хүн ам, орон сууц, мал ХАА-н бусад зүйл, үндсэн хөрөнгийн тооллого зэрэг судалгааны материалыг боловсруулдаг болов.

Статистикийн албаны өмнө тавигдсан чухал зорилтын нэг бол улс хоршоолол, үйлдвэр аж ахуйн байгууллагад анхан шатны бүртгэлийг нэвтрүүлж социалист өмчинд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах явдал мөн.

Энэ үндсэн дээр үйлдвэр аж ахуйн газруудад

анхан шатны бүртгэлийн 200 гаруй маягт заавар боловсруулан баталж мөрдүүлсний дээр ХАА-н нэгдлийн анхан шатны ба н-бо бүртгэлийг шинэчлэв.

Үүний дагуу 10 илүү мянган хүн 65,0 мянган орчим бүртгэлийг хөтлөн улс ардын аж ахуйд нэвтрүүлж байна.

ЗХУ-ын статистикийн байгууллага, мэргэжилтний туслалцаатайгаар улс ардын аж ахуйн бүртгэлийн механикжуулах асуудлыг зөв зохистой шийдвэрлэн механикжуулалт, автоматжуулалтыг удирдлага, бүх төрлийн бүртгэлд нэвтрүүлэх, шинжлэх ухааны өргөн тооцоолол хийх, электрон машин математикийн арга хэрэглэн нийгэм эдийн засгийн процессыг нөлөөлөх хүчин зүйлээр нь судлах зэрэг томоохон ажлуудыг хийхээр статистикийн төв газрын дэргэдх улсын тооцоолон бодох төв статистикийн

СОЦИАЛИСТ ХУУЛЬ ЁСЫГ ХЭЛБЭРЭЛТГҮЙ БИЕЛҮҮЛЬЕ

(Аймгийн Намын идэвхтний хурал)

Сайхан аймгийн Намын идэвхтний хурал Зуунмод хотод болов.

Хуралд «Социалист хууль ёсыг хэлбэрэлтгүй биедүүлж, гэмт хэрэг хэв журмын зөрчилгүй байгууллага, хамт олны хөдөлгөөнийг өрнүүлэхэд Намын байгууллагуудын зорилт» гэсэн илтгэлийг аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга Х. Билгээ тавьж хэлэлцүүлэв. Илтгэгч, манай орны социалист байгуулалтын хэмжээ далайц өсөж нарийсхын хирээр социалист хуулийг хэлбэрэлтгүй биедүүлэх шаардлага өндөржиж байгааг тэмдэглээд тус аймагт гарч байгаа гэмт хэрэг хэв журмын зөрчил олоогийн байдал энэ талаар зохиож буй ажлын ололт дутагдалд тодорхой дүгнэлт хийж, цаашдын зорилтын талаар дэлгэрэнгүй ярих.

Тус хурал дээр аймгийн прокурор, гавъяат хуульч О. Лхамсүрэн, НАХ хэлтсийн дарга Дорж, Борнуурын САА-н Намын хорооны нарийн бичгийн дарга Д. Чүлгэм нарын 10 гаруй хүн үг хэлэв.

Хуралд тавьсан илтгэл, үг хэлсэн хүмүүсийн санал дүгнэлтээс үзвэл:

Тус аймагт гэмт хэрэг, хэв журмын зөрчил дорвитой буурахгүй, харин зарим талаар өсөх хандлагатай байгааг нам, улс, олон нийт, хуулийн байгууллагууд онцгой дүгнэлт хийж социалист хууль ёсыг нарийн чанд сахиж биедүүлэх ажлыг эрс хүчтэй болгохыг шаардаж байна.

Социалист хуулийг сурталчлах ажлын үр нөлөө хангалтгүй, хүмүүсийн

хууль эрхийн мэдлэг шаардлагаас хоцорч байгаа ба гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа үзэл суртал, зохион байгуулалтын ажил нэн дутагдалтай байгаагаас танхайрах, хүмүүсийн амь, биеийг хохироох, социалист өмчийг идэж ашиглах, үрэгдүүлэх явдал гарсаар байна.

Сүүлийн 3 жилд гарсан эрүүгийн хэрэг өдүүлэгчдийн 52,1 хувь ажилчин албан хаагчид, 67,8 хувь нь 18—35 насны залуу хүмүүс байна.

Түүнчилэн тус аймагт сүүлийн 3 жилд гарсан нийт гэмт хэргийн 82,6 хувийг социалист өмчийн болон ууж согтууран бусдын эрх чөлөөнд халдаж танхайрсан, иргэний өмчийг хулгайлсан хэрэг эзлэж байна.

Худалдаа бэлтгэл, хөдөө аж ахуйн байгууллагуудад өр аглагыг багасгах, социалист өмчийг хамгаалах талаар тавьж байгаа хяналт сул, зохиож байгаа тодорхой ажлаар тун хомс байна.

Тус аймгийн Бүрэн, Сэр гэлэн, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Эрдэнэ, Дэлгэрхаан сумдад 1971 оны хоос 1973 онд эрүүгийн хэрэг нилээд хэмжээгээр нэмэгджээ.

Аймгийн ҮЭ-ийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо, аймгийн нэгдлийн зөвлөл, эмэгтгэлчүүдийн зөвлөл зэрэг олон нийтийн болон аж ахуйн байгууллагуудаас хууль эрхийн хүмүүжлийн ажил бараг зохиодоггүй, зохиосон ажил нь үр нөлөө далайц бага байна гэсэн дүгнэлтийг идэвхтний хурал хийв.

Социалист өмч, мал сүргийг идэж ашиглагчдыг,

илрүүлж таслан зогсоох, хохирол төлбөрийг гаргуулах шуурхай ажиллагаа хуулийн байгууллагуудад дутагдалтай байна. Түүнчилэн сум, хот, хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргаандаас ард иргэдэд иргэний үүргийг ухамсарлуулах тэднээс хууль дүрмийг ёсчлон биедүүлэхэд тавих хяналт хангалтгүй байгаа нь зарим хүмүүс хөдөлмөрөөс зайлсхийх, оногдол үүрэг, хураамжуудыг үл төлөх, иргэнийхээ ариун үүргийг элдэв хэлбэрээр зөрчих зэрэг зохисгүй байдал гаргах шалтгаан болж байна. Хөдөлмөрдөх хууль эрхийн хүмүүжил олгох хуулийн суртал нэвтрүүлгийн ажил байнгын болж чадаагүй, алдаг оног компани чанартай зохиогдож байгаагийн хамт хувь хүний хүмүүжүүлэхэд хамт олны үзүүлэх нөлөө хүчтэй биш байгаа нь хэрэг зөрчлийг хааж чадахгүй байна.

Сүүлийн үед шинээр гарч мөрдөгдөж байгаа хуулиудыг чандлан биедүүлэх ажил хангалтгүй байна. НААҮГ, Он аж ахуй ажлын цагийг дүр мэдэн өөрчлөх, Барилга угсралтын контор, Заамар нэгдэлд хөдөлмөр хамгааллын шаардлагыг зөрчиж хүмүүсийг осолд оруулах зэргээр хөдөлмөрийн шинэ хуулийг зөрчжээ. Хэрэг зөрчил гарч буй нөгөө шалтгаан нь зарим цөөн хэсгийн дотор өнгөрсөн нийгмийн үлдэгдэл амь бэхтэй оршиж байгаа явдал мөн.

Согтуурах явдалтай хийх тэмцлийг дутмаг явуулж байгаагаас Эрдэнэ, Баян сум, Зуунмод хот зэрэг газарт хэтэртэл ууж согтууран хүний эрх чөлөө, эрүүл мэндийг хохируулсан явдал ч гарчээ. Дээрх дутагдлуудад дүгнэлт хийж, гарч байгаа хэргийн байдал, бүрэлдэхүүнд шинжлэх ухааны үндэстэй нийгмийн тодорхой судалгаа хийсний үндсэн дээр сумд, байгууллага бүр гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөө зохиож, социалист төрийн хуулийг ёсчлон биедүүлэх ажлыг хүчтэй болгоход нам, улс, хуулийн болон олон нийт, аж ахуйн бүх байгууллагын анхаарлыг чиглүүлэхийн чухлыг идэвхтний хурал онцлон заалав.

Юуны урьд гэмт хэрэг зөрчилгүй болох хамт олны хөдөлгөөнийг өрнүүлэн, роль үүргийг нь эрс өндөржүүлэхэд намын үзэл суртал, зохион байгуулалтын ажлыг тодорхой чиглүүлж, иргэдээс хууль ёсыг нарийн чанд биедүүлэх болгон хүмүүжүүлэх нь чухал байна.

Улс, олон нийт, хуулийн болон аж ахуй, соёлын байгууллага хамт олны ажиллагаанд хууль

ёсын биелэлтийн талаар тавих намын хяналтыг өндөржүүлэх, албан байгууллага хамт олны зөвлөгөөнөөр ажлын хариуцлага сахилга бат, хууль зүйн хэрэгжилтийн асуудал хэлэлцүүлж, шүүмжлэл өөрийн шүүмжлэлийг өрнүүлэн илэрсэн дутагдлыг тэр дор нь тас цохин арилгаж байх явдал шаардагдаж байна.

Хүн амын зонхилох хувийг эзлэж байгаа өсвөр үеийг хүмүүжүүлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгож, төдий чөлөө цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үүний тул 10 жилийн сургуульд өдөр өнжүүлэх бүлэгтэй болгох, клуб улаан буланг тусгай хуваариар хичээл хүмүүжлийн ажил зохиодог болгох, багш нараас зохиох хүмүүжлийн ажлын арга барил, идэвх чармайлтыг өндөржүүлж анги удирдсан багшаас ангийн сурагчдын хүмүүжил сахилга батын талаар хүлээх хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

ХЗЭ, пионерын болон цагдан сэргийлэхэд туслах ОН-ийн бригадаас өдөр тутам дежур эргүүл постуудыг байнга ажиллуулан хүн нэг бүртэй тогтмол ажилладаг болгох нь зүйтэй байна.

Иргэдийг коммунист ёс суртахууны шилдэг чанараар хүмүүжүүлж, хүн хүнээ хүндэтгэдэг, нийгмийн гишүүний биеэ авч явах хэм хэмжээг ягштал дагаж мөрддөг, улмаар нийгмийн мал сүрэг эд хөрөнгийг идэж ашиглах үрэгдүүлэх, хөдөлмөрөөс зайлсхийх танхайрах аливаа илрэлтэй ухамсартайгаар эвлэршгүй тэмцэл явуулдаг болгоход ухуулга суртал нэвтрүүлгийн ажлын гол зорилт оршиж байна.

Түүнчилэн хөдөлмөрдийн хууль эрхийн хүмүүжлийг дээшлүүлэх талаар БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн III чуулганы шийдвэрийг таниулах, хэрэгжүүлэх ажлыг улам хүчтэй болгох ёстой. МАХН-ын Төв Хорооны 24 дүгээр тогтоолын заалтыг биедүүлэх ажлыг оновчтой шуурхай болгох, хөдөлмөрийн шинэ хууль, 111, 120 дугаар зарлигуудыг хэрэгжүүлэх ажлын хэмжээг эрчимтэй сайжруулах шаардлагатай байна.

Д. ТОВУУ

ЭРДЭНИЙ ЭМНЭЛГИЙНХЭН

Эрдэнэ сумын хүний их эмчийн салбар МАХН-ын Төв Хорооны 118 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх асуудлыг хамт олны хурлаар хэлэлцэн хүн нэг бүрийг тодорхой үүрэг амлалттай ажиллуулж сар улирал жилийн ажлыг 1000 баллаар дүгнэн байр эзлүүлж ажиллаж байна.

Үүний үр дүнд хөдөлмөрдөх үйлчлэх эмнэлгийн үйлчилгээ хөнгөн шуурхай болж, эмнэлэг гэгээрлийн суртал нэвтрүүлгийн чанар эхнэлхсын эрүүл мэндийг хамгаалах эмнэлгийн тусламж үзүүлэх, үйлчилгээ хяналтын ажил жигд сайжрав.

Тус эмнэлгийн хамт олон амбулатор, больницын барилга засвар үйлчилгээг чанар сайтай хийжээ.

Сумын төвийн албан байгууллага, айл өрх, бригад сууриудыг эмч эмнэлгийн ажилтан бүрт хувиарлан хариуцуулж эмнэлэг гэгээрлийн ажлыг долоо хоног бүр тусгай графикаар зохион явуулсны үрээр сумын ариун цэвэр соёлжилт дээшилж халдвар төвчний гаралт эрс багасав.

Тус салбарынхан 1974 оны 10 сард ор хоног ашиглалт урьдчилан сэргийлэх үзлэг, тариалын жилийн төлөвлөгөөг 101,8-132,6 хувиар биедүүлснээс гадна амбулатор үзлэг, ам борлуулах төлөвлөгөө 80—85,6 хувьтай байна.

Сумын хэмжээний жирэмсэн эхчүүдийг 100 хувь хяналтанд авч төрөх тасагт 100 хувь амар жуулжээ.

Өнгөрсөн 10 сарын хугацаанд 1500 гаруй хүнд ухуулга сурталчилгаа хийж хол, ойрын 917 дуудлаганд явж малчдад 30 гаруй мянган төгрөгийн эм бараагаар үйлчилжээ.

Ингэж ажилласны үрээр түргэн тусламжийн жоолооч Тожилсүрэн, сувлагч Палам, асрагч Цэцгээ аж ахуйн эрхлэгч Дашзэвэг, эх баригч Доржпалам, бригадын бага эмч Гүнэгдорж нарын зэрэг тэргүүний сайчууд олширчээ.

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж тус салбарынхан аймгийн тэргүүний эмнэлэг болохын төлөө шамдан ажиллаж байна.

Н. НАНЖИД

АМЖИЛТ ИЛТГЭСЭН МӨР

Борнуур сумын ХБ ангийн гуанзны хамт олон 1974 оны хоол борлуулалт, бэлэн бүтээгдэхүүнийхээ жилийн төлөвлөгөөг нэр төрлөөр нь 100, 103,3 хувиар биедүүлж сайхан амжилт гаргав.

Тус гуанзны энэ амжилт нь аялагч тогооч Долгорын хөнгөн шуурхай, санаачлага сайтай ажилтай холбоотой гэж хөдөлмөрчид үнэлж байна.

Д. ДАШЦЭРЭН

эрдэм шинжилгээний институт байгуулагдан ажиллаж эхэллээ.

Статистикийн төв орон нутгийн байгууллагаас улс аймгийн улс ардын аж ахуй соёлын хөгжлийг харуулсан статистикийн эмхэтгэлийг орос, монгол хэл дээр жил бүр тогтмол гаргадаг болсон нь манай ард түмэн өөрийн орны өсч байгаа эдийн засгийн хүчин чадал, хөдөлмөрдийн материаллаг амьдрал, соёл боловсролын цэцэглэн хөгжиж байгаа тухай мэтэж судлахад чухал нөлөө үзүүлж байна.

Өнгөрсөн хугацаанд ЗХУ болон социалист бусад орны статистикийн онол практик туршлагаас суралцаж 500 гаруй дээд 2000 гаруй дунд боловсролтой бүртгэл статистикийн мэргэжилтнийг сурган бэлтгэсэн юм.

ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай харилцан зочин төлөөлөгчид, мэргэжилтэн солилцон туршлага судлуулах ажлыг жил бүр

зохиож, нэгдсэн үндэсний байгууллага Ази, ас Дорнодын статистикийн байгууллагатай харилцаа тогтоон ажиллаж байна.

Ийнхүү статистикийн байгууллага түүхэн хөгжлийн явцад ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай харилцаагаа өргөжүүлж социалист орнуудын статистикийн албаны зохион байгуулалт, онол практик, арга зүйн баялаг туршлагаас суралцаж байна.

Одоо үед статистикийн албаны өмнө удирдлага зохион байгуулалтын Маркс—Ленинч арга барилыг чадамгай эзэмших бүртгэл хяналт, эдийн засгийн судалгааг тууштай нэвтрүүлэн төлөвлөлт эдийн засгийн удирдлагыг төгөлдөржүүлж сайжруулах гол зорилт зогсож байна.

Аймгийн Статистикийн товчооны дарга
Л. НАЦАГДОРЖ

Хоол сайн байна гэж хүмүүс олзуурхан ярилцана. Ингэж хүн ардынхаа сэтгэлийг баяр баядалаар дүүрэн байлгасан гэж тэр нэгэн гуанзанд тогооч Эрдэнэсүрэн ажилладаг.

Хүн ардын минь хоол нь амттай, цай нь халуун байгаасай гэж энэ залуухан бүсгүй эхийн сэтгэлээр ард түмнээ хайрладаг шиг, ард түмэн ч тэр бүсгүйг хайрлана.

Тийм учраас түүнийг Зуунмод хотын АХ-ын депутатаар сонгосон юм.

Энэ гуанзанд манай хотын хамгийн залуу үе ажилладаг.

Тогооч Эрдэнэсүрэн залуучуудтай ажиллахдаа дуртай. Тэр аймгийн ХЗЭ-ийн хорооны бүгд хурлын болон, эвлэлийн үүрийн товчооны гишүүн юм. Түүний бүхий л аж-

лын амжилт бүтээл МХЗЭ-тэй холбоотой.

Тэдний гуаэныг Аймгийн ХЗЭ-ийн хороо шөфлөн авч өдөр тутмын тусалцаа үзүүлдэг. Оюутны ширээнээс ажилчны алдар хүртлэх анхны үеэс тогооч гэдэг мэргэжил тийм ч амаргүй са-

саа гэж ухаант түмний минь цэцлэн хэлсэн нь юутай үнэн билээ.

Хүмүүс Эрдэнэсүрэнг сайн тогооч гэх болсоор уджээ. Хүмүүс яагаад ингэж ярих болсныг зөвхөн жил тутмын төлөвлөгөө биелүүлсэн төдийгөөр дүгнэж болохгүй нь мө-

зааж, үйлдвэрлэлийн зохион байгуулалтаа улам боловсронгуй болгох талаар ихийг бодож, түүнийг хурал зөвлөлгөөнд дээр санал болгон тавина. Тэрээр ажил амьдралын 7 жилдээ магтуулж шагнуулж ч үзсэн, МХЗЭ-ийн 50 жилийн ойн дурс-

Тэр ах дүү орнуудын алдарт хүмүүсийн туршлагаас суралцахсан, тэдэнтэй нүүр учрахсан гэж мөрөөддөг байлаа.

Хүсэл мөрөөдлөө хөдөлмөрөөрөө биелүүлдэг гэдгийг тэр сайн мэднэ.

Тиймээс ч бүх ард түмний социалист уралдааны жил—1973 онд тодорхой үүрэг авч ажиллаад жилийнхээ төлөвлөгөөг 139,4 хувир биелүүллээ.

Энэ нь урьд өмнийн хэд хэдэн жилийн аваргуудын амжилтаас давжээ. Ингэж түүний нэгэн хүсэл мөрөөдөл биелсэн юм. Одоо тэр ЗХУ-а туршлага судалж яваа. Зүйлийг сурч, сурсан зүйлээ ажил болгохсон гэж яари яваа. Удахгүй тэр ирнэ. Сурсан эрдмээрээ төрөлх хотынхоо дайлах болно.

Д. РЕНЧИНДОРЖ

ТЭР УДАХГҮЙ ИРНЭ

М.М.М.М.М.

нагдсан удаа бий.

Гэвч түүний ажилд худалдааны гавьяат ажилтан, мастер тогооч Б. Дашзэвэг гуай сэтгэл харамгүй тусалдаг.

Хоол урлахдаа нэрд гарсан энэ мастер хэдэн зуун шавьтай хүн.

Залуу тогооч Эрдэнэсүрэн тэдний нэг нь юм. «Шавийн эрдэм багшаа-

дээж. Тэд тохитой сайхан байранд, тавтай сууж амттай хоол идэж, үйлчлэгч хүмүүсийн эелдэг зөөлөн харцаанд чин сэтгэлээсээ баярлахдаа л энэ үгийг хэлдэг юм.

Энэ бүсгүй хүмүүст аль болох сайхан үйлчилж тэдний эрэлт хүсэлтийг судлаж хүнд хэрхэн үйлчлэх тухай ажилчиддаа

галын медалиар шагнуулж, аймгийн аварга гэдэг хүндэт алдар нэрийг хүртэхдээ «Би юу хийж бүтээлээ» гэж өөрөө өөрөөсөө асуун улам ихийг бүтээхсэн гэдэг оргилуун сэтгэлээр дүүрэн явна. Эрдэнэсүрэн хэдийгээр нас залуу ч бусдад хэлж сургасныхаа хувьд шавьтай хүн.

ХАМТЫН ҮЗЛЭГ ХИЙВ

Социалист өмчийг хамгаалан бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай МАХН-ын Төв Хорооны 1966 оны 340 дүгээр тогтоолыг хэрхэн биелүүлж байгаа тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 133 дугаар тогтоол энэ оны эхээр гарсан билээ.

Уг тогтоолд: Социалист өмчийг хамгаалах, бүртгэл тооцоо, хяналт шалгалтын ажлыг сайжруулж, худалдаа бэлтгэлийн байгууллагад дутагдал шамшигдал гарч байгаа үндсийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, санхүүгийн довтоод хяналт шалгалтыг хүчтэй болгоход нягтлан бодогч нарын хувийн хариуцлагыг өндөржүүлж эд хариуцагчдаар анхан шатны бүртгэлийн нарийн чанд хөтлүүлэх системтэй арга хэмжээ авахын чухлыг заасантай холбогдуулж саяхан аймгийн нийт худалдааны байгууллагуудын нягтлан бодогч нарын ажилд аймгийн Санхүүгийн хэлтэс, Статистикийн товчоо, Банкны хэлтэс, ХБУ газрын хамтарсан үзлэг хийлээ. Уг үзлэсээр ХБ-ийн 22

анги, трестийн ахлах нягтлан бодогч нарын ажлыг 14 үзүүлэтээр шалгаж дүнг хэлэлцэв.

Аж ахуйн ажиллагаанд хөтөлгөдвөл зохих анхан шатны бүртгэлийг эд хариуцагч бүр бүрэн хөтөлж хөтөлтийн чанарыг сайжруулан баримт эргэлтийн графикийг мөрдүүлж ажилдаа хэвшүүлэх талаар Батсүмбэр, Ондорширээт, Сэргэлэн сумын ХБ анги, Зуунмод хотын ХБ Трест нилээд ажил хийж зохих шаардлагын хэмжээг хангасан байна. Гэвч Эрдэнэсүрэн сумын ХБ анги сарын балансыг тогтмол гаргах, эд хариуцагч нарт гэнэтийн тооллого хийх, барааны нярав нарын хариуцлагаанд байгаа бараанд нягтлан бодогч нар өөрсдөө хяналтын тооллого хийх зэрэг зайлшгүй хийгдвэл зохих ажлыг хийгээгүй, ихэнх ХБ ангиудад энэ ажил хэвшиж чадаагүй ор нэрийн төдий байсан нь шалгалтаар илэрлээ.

Сар, улирал, жилийн балансыг чанар үзүүлэлт сайтай хугацаанд нь гаргаж аж ахуйн ажилла-

гааны үр дүнг байгууллагын хамт олны зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэн холбогдох арга хэмжээ авах талаар Баян, Баянцагаан, Эрдэнэсүрэн, Эрдэнэ сумын ХБ ангиудогтхончанхаарч байгаагүйгээс эдгээр сумдын ХБ ангиуд нь шинээр олон мянган төгрөгийн өр нэмэгдүүлжээ.

Ажиллагааны зардлыг хамдруулан, дотоод ноёц бололцоог ашиглах, улсын бэлтгэлийн чанарыг сайжруулах талаар Баян, Баянзүрх, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдын ХБ ангиуд хангалтгүй ажиллаж байна. Үзлэгийнхэн эдгээр ажлын дутагдлыг илрүүлэн цаашид авах арга хэмжээг тодорхой заав.

Үзлэгийн дунгийн хуралд аймгийн Санхүүгийн хэлтсийн дарга Д. Төмөр оролцож сумдын ХБ ангиудын ахлах нягтлан бодогч нарт цаашид ажиллах талаар зөвлөгөө өгөв.

Дунгийн хурлын дараа нягтлан бодох бүртгэл тооцооны ажилтнуудын үзүүлэх сургууль хийж хариуцагч туршлагаа солилцох практик хичээл заалаа.

Д. РЕНЧИНДОРЖ
Х. ДАШЖАМЦ

ТАЙЛАН СОНГУУЛИЙН ХУРАЛД САЙН БЭЛТГЭЭ

Тогтоол. (Түрүүч нь II нүүрт)

лүүлэх талаар өнгөрсөн жилд зохиосон ажлаа дүгнэхийн хамт тайлан сонгуулийн хуралтай хамтатган явуулах үйлдвэрчний эвлэлийн бүлгийн ажилд хийх нэгдүгээр шатны үзлэгт амжилттай дүн үзүүлэхэд оршино.

Өнгөрсөн онд болсон үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагын тайлан сонгуулийн хуралд бүх гишүүдийн 90 хувь нь оролцож 10 гаруй хувь нь үг хэлжээ.

ҮЭ-ийн анхан шатны зарим байгууллага 1973 оны тайлан сонгуулийн бэлтгэлажилд хангалтгүй анхаарсан дутагдал үзэгдэж байв.

Одоо анхан шатны зөвлөл, хороо, бүлэг бүр тайлан сонгуулийн бэлтгэл хангах төлөвлөгөө гарган тодорхой ажил зохиох нь чухал. Юуны өмнө 1974 онд дэвшүүлсэн зорилт, хороо, бүлэг, комисс, идэвхтэн бүрийн хийсэн ажлыг дүгнэж түшиглэсэн байгууллагуудын төлөвлөгөө, социалист уралдаанд авсан үүргийн биелэлтийг нэг бүрчлэн үзэж дүгнэлт хийхээс эхлэх хэрэгтэй.

Тайлангийн хугацаанд дээд байгууллагын болон өөрийн гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтэнд гүйцэтгэлийн шалгалт хийж үр дүнг тооцвол зохино. Салбар хороо бүлгүүдийн тайлан сонгуулийн хурлуудыг бэлтгэл сайтай хийлгэж, ҮЭ-ийн гишүүдийн мандлал, 1974 оны социалист уралдаанд авсан үүргийн биелэлтийг гаргаж үнэлэлт дүгнэлт өгөхийн хамт комисс идэвхтэн бүрийн ажлыг хэлэлцсэн байвал зохино. Үйлдвэрч-

ний эвлэлийн олон талт ажлыг олон нийтийн үүсгэл санаачилгаар хийх хөдөлгөөнийг өрнүүлэх замаар мэдлэг чадвар, нэр хүндтэй, зарчимч өндөр шаардлагатай тэргүүний хүмүүсээр бэхжүүлэх урьд нь ажиллаж байсан дадлага туршлагатай идэвх санаачилгатай хүмүүсийг цаашид хэвээр ажиллуулахыг нэг адил анхаарах нь зүйтэй.

ҮЭ-ийн анхан шатны зөвлөл, хороо, бүлэг бүхэн тайлан илтгэл болой хурлаас гаргах шийдвэрт өөрийн онцлогт тохируулан аль нэг тодорхой асуудал дэвшүүлэхийн хамт МАХН-ын Төв Хорооны Үлс төрийн Товчооноос Сэлэнгэ аймгийн Намын хорооны илтгэлийг авч гаргасан тогтоолын заалт бүрийг хэрэгжүүлэн үйлдвэрчний эвлэлийн хорооны эрхийн дүрийг тууштай биелүүлэх, V-таван жилийн төлөвлөгөөний эцсийн жил—1975 оны төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж үйлдвэрчний эвлэлийн бүх ажлын үр нөлөө, дайчин чадварыг дэвшүүлэх нь зөвлөл, хороо, бүлэг, идэвхтэн бүрийн зорилт мөн.

Үйлдвэрчний эвлэлийн анхан шатны байгууллагын тайлан сонгуулийн хурлын үеийн ажлын чухал хэсэг нь 1974 оны төлөвлөгөөг биелүүлэх, мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг гүйцэд хангаж, ЗХУ-ын нам засгийн хүндэт зочдыг хөдөлмөрийн өндөр бүтээлээр угтах уралдаан өрнүүлж Зөвлөлтийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагын ажлын баялаг туршлагаас улам ихийг суралцах явдал мөн.

Б. БАДАРЧ

Д. ТОВУУ



БНАВУ-д олон ороо тасалгаа бүхий орчин үеийн сууцны барилгуудыг барих ажил оржээ байна. Зөвхөн энэ оны 6 сард нийсдэл Ханой хотод 40 мянга гаруй хавтгай дорволжин метр талбай бүхий орон сууцны барилга ашиглалтанд оржээ.

ЗУРАГ ДЭЭР:

Ханой дахь барилга байгууламж

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ